



ЗАВХАН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 0/77.

Улиастай

Спортын заал ашиглалтын журам
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.2 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дэх хэсгийг, тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эзэмшлийн байр (спортын заал, танхим, павильон), гадна талбайн түрээсийн төлбөрийн үнийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж, түрээсийн төлбөрийг төвлөрүүлэхдээ данснаас дансны хооронд болон цахим төлбөрийн систем ашиглах (бэлэн мөнгө ашиглахгүй, хувь хүний дансаар дамжуулахгүй байх)-аар төлөвлөн ажиллахыг ерөнхий нягтлан бодогч (Э. Сэвжидмаа), нярав (Ч. Батдэлгэр) нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Гансүх)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



М.БАТБАЯР

فمنش
44/205

حجرت و فاحر فاحر بقصر

[Handwritten signature]

Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

СПОРТЫН ЗААЛ АШИГЛАЛТЫН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

Энэхүү журам нь Биеийн тамир, спортын тухай хууль, төсвийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам бусад тогтоомжид нийцсэн байна.

Энэхүү журмаар "Биеийн тамир, спортын газар"-ын спортын заалаар үйлчлэх, үйлчлүүлэх болон адилтган үзэх бусад харилцааг зохицуулна.

ХОЁР. Заалаар үйлчлэх зарчим

2.1 Тус спортын газрын үндсэн чиг үүрэг сургалт, / секц дугуйлан /-ын хувийн үйл ажиллагааг алдагдуулахгүй сургалтын бус цагаар спортын заалыг аж ахуй нэгж байгууллага иргэдэд үнэ төлбөртэйгөөр ашиглуулах

2.2 Тус спортын заалаар үйлчлүүлэх аж ахуй нэгж, байгууллага иргэдтэй газрын заал зохион байгуулагч хамтын ажиллагааны гэрээ байгуулна.

2.3 Хамтран ажиллах гэрээ нь өдөр сар улирал жилээр гэсэн хугацаатай гэрээнд хуулийн дагуу заалтуудыг тодорхой тусгаж байгууллагын даргаар баталгаажуулна.

2.4 Спортын зааланд явуулах сургалт /секц дугуйлан/ гэрээгээр ажилладаг ахуй нэгж байгууллагуудын цагийн хуваарийг тус газрын спортын хэлтсийн дарга шинэчлэн газрын даргаар батлуулна.

2.5 Спортын заалны нэг цагийн үйлчилгээний төлбөр 40000, тэмцээн уралдаан явуулах нэг өдрийн хөлс 250000 төгрөг ба төлбөрийг урьдчилан төлж цагийг баталгаажуулна. Спортын заалны ажиллах хуваарь 07.00-22.00 цаг байх ба заалны түрээсийн хугацаа 22:00 цагаас хэрсэн тохиолдолд нэг цагийн тариф /1 цагийн 40000/- аар тооцон төлбөр дээр нэмж бодогдоно.

2.6 Спортын заалаар үйлчлүүлснээс орсон орлогыг хууль журмын дагуу нягтлан бодогч бүртгэлд тусгана.

2.7 Тус байгууллагын жижүүрүүд заалны батлагдсан хуваарийн дагуу байгууллага аж ахуй байгууллага иргэдэд үйлчлэхэд дараах үүргийг хүлээнэ.

- Спортын зааланд сургалт /секц, дугуйлан/ тэмцээн уралдаан, арга хэмжээ эхлэхээс өмнө цэвэрлэсэн байх
- Спортын заалны алчууруудыг бэлтгэл эхлэхээс өмнө угааж бэлдсэн байх

2.8 Спортын заалаар нэг удаад үйлчлүүлэх хүний тоо 25-30 байна.

2.9 Спортын заалаар үйлчлүүлэгчдийн үнэт эдлэл, бэлэн мөнгө, солих хувцас, гар утас, зэрэг эд зүйлс алдагдсан буюу эвдэрч гэмтсэн тохиолдолд хариуцахгүй.

2.10 Дээд газрын шийдвэрээр уралдаан тэмцээн болон олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах үйл ажилла тодорхой хугацаагаар зогсоох шийдвэр гарсан тохиолдолд тухай үед цагийг нөхөж олгохгүй болно.

Биеийн тамир, спортын газар